



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 19 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн
хөгжлийн газрын эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/423 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дүгээр сарын 04-ний өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,880,000.00 (найман сая найман зуун наян мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газарт зөвшөөрсүгэй.

2.Хавсралтанд заасан 2 нэр төрлийн 8,880,000.00 (найман сая найман зуун наян мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500681

Нийслэлийн Өмчийн харилцаагч
2024 оны... дугаар түүх
... дугаар түүх

Байгавууллаагын нэр: Нийслэлийн Дагуул хот эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар

Байгууллагын нэр: Нийслэлийн Дагуул хот эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар									
д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигл асан жил	Хэмж их нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл
1	Байгууллагын цахим хуудас	2	ш	1	8,000,000.00	8,000,000.00	2,799,999.93	5,200,000.07	MУ-ын Засгийн газрын 2024.02.28-ны өдрийн 81, НЗД-ын 2024.04.12-ны өдрийн А/423-р захирамжийн дагуу татан буугдсан
	Бусад биет бус хөрөнгийн дүн			1	8,000,000.00	8,000,000.00	2,799,999.93	5,200,000.07	
2	Санхүүгийн програм/ascolous	2	ш	1	880,000.00	880,000.00	352,000.08	527,999.92	устгах
	Программ хангамжийн дүн			1	880,000.00	880,000.00	352,000.08	527,999.92	устгах
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн			2	8,880,000.00	8,880,000.00	3,152,000.01	5,727,999.99	
	Үүнээс. Худалдах хөрөнгө								
	Устгах хөрөнгө								
	Татан төвлөрүүлэх хөрөнгө								
	Худалдсанаас олох орлого								
	НӨХГ-т төвлөрүүлэх /30%/								